

## “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### 1.1. Тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн

Хүний амьд явах, эрүүл байх нь өдөр тутмын анхдагч хэрэгцээ болсон хүнснээс шууд хамааралтай. Шим тэжээллэг, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсээр хүн амыг жигд, хүртээмжтэй хангах нь улс орон оршин тогтнох, тогтвортой хөгжих тулгуур болно.

Энэхүү цогц асуудлыг хүнсний аюулгүй байдал гэсэн ойлголтын хүрээнд авч үздэг бөгөөд “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг хэмээн заасан байдаг. Монгол Улсын Хүнсний тухай хуульд “хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг хэлнэ гэж томъёолсон. Иймд хүнсний аюулгүй байдлын тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлыг бодитой тодорхойлох нь Монгол хүн эрүүл байх нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал” -ыг баримтлан хүнсний аюулгүй байдлын тулгамдаж буй асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээг хүнсний хангамж, хүртээмж, хүнсний илчлэг, шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн үндсэн 4 үзүүлэлтээр тодорхойлов. Үүнд:

Хүнсний хангамж: Хүн амын хүнсний хангамжийг гол нэрийн 16 бүтээгдэхүүнээр тооцоход 2017 онд дундаж дүнгээр 61.9 хувьтай байна. Хүнсний хангамжийг улсын түвшинд үнэлдэг тогтвортой байдал, тэнцвэртэй байдал гэсэн 2 шалгуур хангалтгүй түвшинд байна.

Хүнсний хүртээмж: Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар 2017 онд улсын дунджаар мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, гурил, саахар чихрийн зүйл гэсэн 6 нэрийн бүтээгдэхүүний хүртээмж аль ч улиралд хангалттай, дундаж дүнгээр хүнсний хүртээмж зуны улиралд 72.7, сэрүүний улиралд 71.2 хувьтай байна.

Хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг, харин хотод гурилан бүтээгдэхүүн, саахар, чихрийн зүйл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамал, өндөг, цөцгийн тосыг улсын дунджаас тус тус дээгүүр хэрэглэсэн дүнтэй.

Хүнсний илчлэг, шим тэжээл: Үндэсний статистикийн хорооны судалгааны дүнгээс үзэхэд, улсын дунджаар жишсэн нэг хүний хүнснээс авах илчлэг болон үндсэн шимт бодисын хэмжээ зөвлөмж нормтой харьцуулахад аль ч улиралд давсан, харин байршлын хувьд ялгаатай буюу хот, хөдөөд харилцан адилгүй байна.

Хүн амын хоол, тэжээлийн үндэсний 5 дугаар судалгаагаар, жирэмсэн эмэгтэйчүүдийн 75.4 хувь, 5 хүртэлх насны хүүхдийн 61 хувь, эрэгтэйчүүдийн 40.4 хувь нь Д амин дэмийн дуталтай, нөөц дутмаг түвшин бүх бүлэгт 20-иос дээш хувьтай байгааг тогтоосон. Мөн хүн амын дунд А амин дэмийн дутлын тархалт “дунд зэрэг”, төмөр, иодын дутал тодорхой түвшинд байсаар байгаа тул олон төрлийн хүнс хэрэглэх, өргөн хэрэглээний

хүнснийг баяжуулахыг зөвлөмж болгосон. Түүнчлэн 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 64.9 хувьд нь хүнсний баталгаат байдал ямар нэг хэмжээгээр алдагдсан байна. Хүн амын дундах илүүдэл жин, таргалалт нийгмийн эрүүл мэндэд ноцтой үр дагавар учруулах түвшинд хүрсэн тул эрүүл хооллолт, зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, амин дэм, эрдсээр баялаг хоол хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн судалгааны дүнд дурджээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал: Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн тайлангаас үзвэл, улсын хэмжээнд 2017 онд хүнсний бүтээгдэхүүний 13.6 мянган дээжинд хийсэн нянгийн бохирдолтын шинжилгээгээр 2.4 хувь, 9.6 мянган дээжинд хийсэн химийн бохирдолтын шинжилгээгээр 4 хувь нь тус тус бохирдолтой гарчээ. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтаар 2017 онд илэрсэн нийт 28.2 мянган зөрчлийн 19.2 хувийг ариун цэвэр, эрүүл ахуйн, 13.6 хувийг дотоод хяналтын, 12.6 хувийг хадгалалт, тээвэрлэлтийн, 11 хувийг түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын зөрчил тус тус эзэлсэн байна. Хоол, хүнсээр дамжих өвчний дэгдэлт 9 удаа бүртгэгдэж, 133 хүн өвчилсөнөөс 73.7 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн. Цаашид хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Хүнсний аюулгүй байдлыг улсын түвшинд нэгтгэн үнэлэхэд хүнсний илчлэгээс бусад үзүүлэлт хангагдаагүй буюу ерөнхий дүнгээр “*хангалтгүй*” байна. Иймд хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн тус бүрээр тодорхой зорилт дэвшүүлэн бодит үр дүнд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## 1.2. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Эрх зүйн үндэслэл: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхээр тусгасан.

Практик шаардлага: Засгийн газраас "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийг 2009-2016 онд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн төгсгөлийн шатны хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзвэл, тус хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 85.4 хувь, шалгуур үзүүлэлтийн биелэлт дунджаар 74.7 хувьтай байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэд санхүүжилт дутагдалтай байсан нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн болохыг мөн дурджээ. Хөтөлбөр хэрэгжсэнээр хүнсний дотоодын үйлдвэрлэл дунджаар өссөн, бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдсэн, хүн амын хүнсний хангамж харьцангуй тогтворжсон зэрэг эерэг өөрчлөлт, үр дүн гарсан байна. Гэвч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг үр ашигтай, тогтвортой эрхлэх, боловсруулах үйлдвэрлэлийг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулах асуудал тулгамдсан хэвээр байна.

## 1.3. Хөтөлбөрийн хамрах хүрээ:

“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр нь Засгийн газраас баталсан “Хүнсний ногоо”, “Малын эрүүл мэнд”, “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөр болон олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжиж буй холбогдох төслүүдтэй уялдаж, үндэсний хэмжээнд хэрэгжинэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА

2.1. Хөтөлбөрийн зорилго нь хүнсний аюулгүй байдлыг хангаж, Монгол хүн эрүүл байх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтоор хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.2.1. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 2.2.2. Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих;
- 2.2.3. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;
- 2.2.4. Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх;
- 2.2.5. Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1. Хөтөлбөрийн "Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 3.1.1. Хот, суурин газрын ойролцоо мах болон сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэх, боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллахыг бодлого, арга зүйгээр дэмжих;
- 3.1.2. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тосны ургамал, чихрийн манжинг таримлын сэлгээнд нэвтрүүлэх;
- 3.1.3. Хүн амын хүнсний хэрэглээний зөвлөмжид шинээр нэмэгдсэн загас, шувууны махны чиглэлийн аж ахуйг дэмжих;
- 3.1.4. Өндөгний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг борлуулалтаар дэмжих;
- 3.1.5. Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан дотоодын үйлдвэрлэл хязгаарлагдмал цагаан будаа, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангахад гадаад худалдааны түнш орнуудтай яриа хэлэлцээ хийх;
- 3.1.6. Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих тарифын болон тарифын бус зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.1.7. Хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэл, тээвэр-логистикийн сүлжээ байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;
- 3.1.8. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх арга хэмжээг орон нутагт хувийн хэвшлийн оролцоотой зохион байгуулах;
- 3.1.9. Монгол Улсын нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх.

3.2. Хөтөлбөрийн "Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих" зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 3.2.1. Хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх чиглэлээр "Ээжийн сонголт – Эрүүл хүнс" болон "Өглөөний цай" хөдөлгөөн өрнүүлэх;
- 3.2.2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол олгох сургалтын байгууллагын хичээлийн хөтөлбөрт "Хоол, хүнсний зөв сонголт, зохистой хэрэглээ" агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх;

- 3.2.3. Хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэнд тухайн бүтээгдэхүүний шим тэжээлийн үзүүлэлтийг тусгаж хэвшүүлэх;
  - 3.2.4. Хүнсний бодит хэрэглээний судалгааг улирлаар бүсчлэн хийж, зөвлөмж боловсруулах;
  - 3.2.5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын хүснэгтийг 3 жил тутамд шинэчлэх;
  - 3.2.6. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны жор, орцын зохистой харьцааг хүн амын физиологийн зөвлөмж хэмжээтэй уялдуулан тогтоож, мөрдөх;
  - 3.2.7. Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнсний дотоодын үйлдвэрлэлийг гадаад улс, олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлд хамруулах замаар дэмжих;
  - 3.2.8. Сахар чихрийн зүйл, транс тос, давсны агууламж өндөртэй бүтээгдэхүүний нийлүүлэлт, хэрэглээг бууруулах арга хэмжээ авах;
  - 3.2.9. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын тогтвортой хөгжлийг дэмжих “Монгол үндэстний хоол” төсөл боловсруулж хэрэгжүүлэх.
- 3.3. Хөтөлбөрийн “Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
- 3.3.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэлийг боловсронгуй болгох;
  - 3.3.2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах, ул мөрийг мөшгих мэдээллийн цахим сан бий болгох;
  - 3.3.3. Ургамал хамгааллын бодис, бордоо, малын эмийн чанар, аюулгүй байдал, хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах;
  - 3.3.4. Хүнсний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн /GAP/, хүнсний сүлжээнд эрүүл ахуйн /GHP/, хүнсний боловсруулах салбарт үйлдвэрлэлийн /GMP/ зохистой дадлыг нэвтрүүлж баталгаажуулах;
  - 3.3.5. Улс, орон нутгийн түвшний хүнсний аюулгүй байдлын лабораториудын чадавхийг сайжруулах, итгэмжлэлийн хүрээг өргөтгөх, олон улсын итгэмжлэлд хамруулах;
  - 3.3.6. Хүнсний үйлдвэрүүдэд дотоод хяналтын лаборатори байгуулах, бэхжүүлэхэд нь санхүүгийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
  - 3.3.7. Хүнсний салбарын техникийн зохицуулалт, үндэсний стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах, олон улс, бүс нутгийн стандартыг нутагшуулах;
  - 3.3.8. Олон улсын Хүнсний хууль эрх зүйн хороотой хамтран ажиллах Кодексийн үндэсний зөвлөлийг чадавхжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх;
  - 3.3.9. Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэл, импортын кластер байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;
  - 3.3.10. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах;
  - 3.3.11. Хүнсний зориулалтын тээврийн хэрэгсэл болон агуулахын тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр импортлох санхүүгийн механизмыг бүрдүүлэх;
  - 3.3.12. Хүнсний худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
  - 3.3.13. Мал төхөөрөх үйлдвэрлэл эрхлэх асуудлыг аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлөөр зохицуулах асуудлыг судлах;
  - 3.3.14. Хоол, хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн шалтгааныг нарийвчлан тогтоож бүртгэх, эмнэлэгт хандаагүй тохиолдлыг тандан судлах, хариу арга хэмжээ авах шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх;
  - 3.3.15. “Хүнсний аюулгүй байдлын цаг” цуврал нэвтрүүлгийг Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран бэлтгэж хэрэглэгчдэд тогтмол хүргэх.

3.4. Хөтөлбөрийн “Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 3.4.1. Худалдааны түнш орон, бүс нутагтай байгуулах Чөлөөт худалдааны хэлэлцээрт тухайн зах зээлд хүнсний бүтээгдэхүүн экспортлох тарифын хөнгөлөлттэй нөхцлийг тусгах;
- 3.4.2. Худалдааны түнш орнуудтай байгуулсан мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн хэлэлцээрийг хянан үзэх, шинэчлэх, шинээр байгуулах;
- 3.4.3. Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- 3.4.4. Экспортын баримжаатай хүнсний боловсруулах салбарт технологийн шинэчлэл хийх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын сан байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;
- 3.4.5. Экспортлох боломжтой хүнсний нэр, төрлийг тодорхойлох, үйлдвэрлэлийг нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Үйлдвэрлэлийг дэмжих сангаар тэргүүн ээлжинд дэмжих механизмыг бүрдүүлэх;
- 3.4.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах дотоодын хүнсний нэр, төрлийг нэмэгдүүлэх;
- 3.4.7. Монгол Улсын хүнсний экспортыг “өндөр үнээр, цөөн тоогоор” стратегийн хүрээнд хэрэгжүүлэх;
- 3.4.8. Газар зүйн заалттай хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, экспортыг гадаад улс, олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлд хамруулж дэмжих;
- 3.4.9. Органик мал аж ахуй, газар тариалан, зөгийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр “Органик Монгол хүнс” төслийг хэрэгжүүлэх;
- 3.4.10. Байгалийн ургамал болон ойн дагалдах баялгийг ашиглан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой талбайн хил заагийг тодорхойлох, нөөцийн үнэлгээ хийх, байгаль орчны улсын мэдээллийн санд бүртгэх;
- 3.4.11. Органик газар тариалан, мал аж ахуй эрхлэх бүсийг тогтоох, “Органик сум” хөдөлгөөнийг өрнүүлэх, “Органик ирээдүй” олон улсын арга хэмжээ зохион байгуулах.

3.5. Хөтөлбөрийн “Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 3.5.1. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх, санал боловсруулах;
- 3.5.2. Хүнсний салбарт инноваци, шинэ технологи нутагшуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үүрэгтэй Судалгаа хөгжлийн төвийг аж ахуйн тооцоотой байгуулах асуудлыг судлах;
- 3.5.3. Хүнсний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх;
- 3.5.4. Хүнсний аюулгүй байдлын түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлт, тооцох аргачлалыг боловсронгуй болгох;
- 3.5.5. Хүнсний сорилт, чанар, аюулгүй байдлын итгэмжлэгдсэн лабораториудын сүлжээг зохион байгуулах;
- 3.5.6. Хүнсний салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, хүнсний сүлжээнд зохистой дадлын сургалт зохион байгуулах зэрэг төрийн чиг үүргийг салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, их, дээд сургуульд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх;
- 3.5.7. “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт”-ыг хүнсний салбарын мэргэжлийн онцлогтой уялдуулж шинэчлэх;

- 3.5.8. Хүнсний салбарт эрэлт өндөртэй мэргэжлийг Монгол Улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлд хамруулах, тэргүүний оюутнуудад хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний нэрэмжит тэтгэлэг олгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх;
- 3.5.9. Монгол Улс хүнс экспортлогч гүрэн болох стратегийн хүрээнд хүнсний салбарын мэргэжил сурталчлах өдөрлөгийг жил бүр зохион байгуулж хэвших;
- 3.5.10. Хүнсний боловсруулах салбарын нарийн мэргэжлийн ажилтныг гадаад улсын ахисан шатны сургалтад тогтмол хамруулах механизмыг бүрдүүлэх.

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл хяналт тавьж, салбар дундын нэгдсэн удирдлагаар хангана.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан зохион байгуулна.

4.3. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурал харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

- 4.4.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 4.4.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- 4.4.3. гадаадын хөрөнгө оруулалт;
- 4.4.4. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;
- 4.4.5. Концессын гэрээ
- 4.4.6. бусад эх үүсвэр.

#### ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

- 5.1.1. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдал хангагдсан байна.
- 5.1.2. Хүн амын хүнсний шим тэжээллэг чанар сайжирсан байна.
- 5.1.3. Хүнсний сүлжээний бүх шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдсан байна.
- 5.1.4. Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадвар дээшилж, экспортын баримжаатай хөгжих нөхцөл бүрдсэн байна.
- 5.1.5. Хүнсний экспортын хэмжээ нэмэгдсэн байна.
- 5.1.6. Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоо бий болсон байна.

5.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойлно:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2017/	Хүрэх түвшин /2023/	Мэдээллийн эх сурвалж
Хүнсний хангамжийн тогтвортой байдал	хувь	49.3	70.0	ХХААХҮЯ
Хүнсний хүртээмж	хувь	71.9	80.0	ҮСХ
Хүнснээс авах илчлэг	ккал	3065.9	2400.0	ҮСХ

Хүнснээс авах үндсэн шим тэжээл	гр	зөвлөмж хэмжээнээс давсан	зөвлөмж хэмжээнд	ЭМЯ, НЭМҮТ
Хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх итгэмжлэгдсэн лаборатори	тоо	91	120	ҮСХ, СХЗГ
Хоол, хүнсээр дамжих өвчний дэгдэлт	удаа	9	0	ЭМЯ
Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн үндэсний стандарт	хувь	36.8	50.0	СХЗГ
Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн үйлдвэр	тоо	7	Жилд 1-ээс доошгүй	СХЗГ
Баталгаажсан органик хүнсний нэр төрөл	тоо	0	3	СХЗГ, ХХААХҮЯ
Хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспортын дүн	сая ам.дол	22.9	100.0	ГЕГ
Хүнсний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сан	сан	0	1	ХХААХҮЯ

5.3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.